



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/19

Улаанбаатар хот

Ажлын байрны тодорхойлолт шинэчлэн
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай


Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Нийслэлийн Засаг Даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын бүтцийг батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Ажлын байрны тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг Даргын 2017 оны “Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрэм, ажлын байрны жагсаалт батлах тухай” А/28 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт боловсруулах нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Захирагчийн ажлын албаны албан хаагчдын албан тушаалын зорилго зорилт, чиг үүрэг түүнийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчид тавигдах шаардлагыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Э.Энхцэцэг	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Т.Хэрлэн	Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
	Ц.Рэгзэдмаа	Аудит дотоод хяналтын хэлтсийн дарга
	Г.Ууганбаяр	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
	Б.Эрдэнэчимэг	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Р.Даваасүрэн	Инженерийн байгууламжийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Э.Батжаргал	Аудит, дотоод хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн

С.Аригуун	Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн Хог хаягдлын асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн
М.Гансэлэм	Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн Тохижилтын асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн
Д.Эрдэнэцэцэг	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн
Э.Уянга	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Д.Мөнгөндуулга	Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн

2. Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын чиг үүрэг, хууль тогтоомжийн дагуу шинэчлэн боловсруулан, ажлын байрны шинжилгээ хийж үүрэг бүхий ажлын хэсэг хянаж, 2019 оны 02 дугаар сарын 10-ны дотор Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын хэсэг /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
 БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
 ДАРГА  С.ГАНТӨМӨР

